



# МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ 2010/01

## Үнэ № 01(01)

### Үнэ

#### Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

Хэрэглээний үнийн улсын индекс (ХҮУИ) 2010 оны 1 дүгээр сард өмнөх сартай харьцуулахад 2.3 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 5.7 хувиар тус тус өссөн байна (Хүснэгт 1).

Ерөнхий индекс өмнөх сартай харьцуулахад 2.3 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 4.6 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний үнэ 1.6 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Түүнчлэн согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.2 хувь, хувцас, бөс бараа, гутлынх 0.9 хувь, гэр ахуйн тавилга, барааных 0.4 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээнийх 0.3 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээнийх 0.1 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээнийх 3.4 хувиар тус тус өсчээ. Харин эм, тариа, эмнэлгийн үйлчилгээнийх 0.3 хувиар буурч, тээвэр, боловсрол, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ тогтвортой байв (Хүснэгт 1).

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ улсын дүнгээр 2010 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад бүх бүлгийн үнэ дүнгээрээ 3.0-14.4 хувиар өсчээ.

#### Хэрэглээний үнийн улсын индекс, бүлгийн дүнгээр, хувиар

Хүснэгт 1

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин, хувиар	2010- I	
		2009- I	2009- XII
<b>Ерөнхий индекс</b>	<b>100.0</b>	<b>105.7</b>	<b>102.3</b>
Хүнсний бараа, ундаа, ус	39.7	103.3	104.6
Согтууруулах ундаа, тамхи	2.8	112.3	100.2
Хувцас, бөс бараа, гутал	15.3	111.2	100.9
Орон сууц, ус, цахилгаан, түлш	10.8	103.0	101.6
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	5.6	108.9	100.4
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	1.8	109.1	99.7
Тээвэр	9.0	103.3	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	2.9	105.1	100.3
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.1	103.7	100.1
Боловсролын үйлчилгээ	5.4	109.9	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	1.0	114.4	103.4
Бусад бараа, үйлчилгээ	2.7	112.1	100.0

ХҮУИ 2009 оны 1 сард өмнөх сарынхаас 0.8 хувиар өссөн бол 2010 оны 1 дүгээр сард өмнөх сарынхаас 2.3 хувь өсч 1.5 пунктээр нэмэгджээ (Зураг 1).

Зураг 1

Хэрэглээний үнийн улсын индекс, 2008-2010 оны сараар  
(өмнөх оны 12 сар =100)

